

МЭДЭЭЛЭЛЖСЭН НИЙГМИЙН ҮНДСЭН АСУУДАЛ БА МОНГОЛ ОРОН

MAIN ISSUE OF INFORMATION SOCIETY AND MONGOLIA

Ц.Батбаяр

Дэд профессор, Философийн ухааны доктор
(Ph.D)

Товч агуулга: МТ-мэдээллийн технологи, МХХТ-мэдээлэл харилцааны технологи, МХБАЗ-мэдээлэл харилцааны боловсруулах арга зүй, МШХХ-мэдээлэл шуудан харилцаа холбоо, ҮХШХ-үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, ХАОСТ-хүн ам, орон сууцны тооллого

Abstract: The essence of information society information society in Mongolia is analysed, and suggestion and recommendations were developed on how to build The society on theoretical basis. Information social issues were studied on example of Russia, USA, and Japan etc.

Key words: *Philosophical theory of information society, structure of information society, principles for setting up information society, information infrastructure, usage, tendency and scanary in Mongolian society*

Оршил

Уг өгүүлэлд мэдээллийн нийгэм, түүний мөн чанар юу болох, мэдээлэлжсэн нийгэм бусад нийгмийн организмуудаас юугаараа ялгарах, түүний зарчмууд, сүлжээний хэрэглээ, боломж, аюул занал, сул болон давуу талыг танин мэдэхүй, онол, арга зүй, практикийн нэгдэлд нь организмчлах, хүнчлэх, хандлагаар авч үзлээ. Мэдээлэлжсэн нийгмийн онолын талаар дорвитой судалгаа хийсэн оросын эрдэмтэд бол Кузьмин.Е.И, Фирсов.В.Р, Кеван.К, Панарин.И.Н, Тузовский.И.Д, Юзвишин.И.И, Яковец.Ю.В, Якунин.В.И, Иноземцев.В.Л нар юм. Мөн Д.Белл, О.Тоффлер, Ю.Хаяаши нар өөрийн бүтээлдээ тодорхой тусгасан байдаг. Монголын судлаачдаас миний бие уг сэдвээр зохиол бичиж хамгаалаад байна. Ялангуяа. Информационное общество и его реальное состояние в современной Монголии”. “Философия, социология, политология, культурология. № 14, Улан-Үдэ., 2012 сэтгүүлд өгсөн өгүүлэлдээ энэ талаар тодорхой авч үзсэн байгаа.

Монголын нийгэмд мэдээллийн нөөц нь ямагт байсан боловч түүнийг эдийн засгийн болон бусад ямар нэгэн категори гэж авч үзэж байсангүй, мэдээллийн нөөцийг мэдлэг, инноваци гэж ойлговол нийгмийн мэдээллийн нөөц нь түүнийг хуримтлуулж, дүн шинжилгээ хийх боломж бүхий бүтээсэн

хүмүүсээсээ тусгаарлагдсан мэдлэг мөн. Мэдээлэлжүүлэлтийн соёл нь хүний ерөнхий соёлын нэг бүрэлдэхүүн хэсэг мөн тул хүн болгон зохих түвшинд эзэмшсэн байх ёстой үнэт зүйлс юм. Соёл, онолын мэдлэг, мэдээллийг аж үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон дэлхийн глобал зах зээл дээр гаргах нь үндэстний хийгээд салбарын хөгжлийн нэг чухал гарц мөн.

Орчин үеийн нийгмийн организмуудад гарч буй өөрчлөлтийн талаар судлаачид сүлжээний капитализм, мэдээллийн капитализм, инновацийн капитализм, капитализмжсаны дараах, хөдөлмөрийн дараах, эдийн засгийн дараах, үйлчилгээний технологитой, аж үйлдвэржсэний дараах, мэдээлэлжсэн, виртуаль, постмодерн, програмчлагдсан нийгэм гэхчлэн нийгмийн аль нэг тал дээр тулгуурлан олон тал хандлагаар авч үзэж, янз бүрээр нэрлэж, тайлбарлаж байгаа ч нэг ерөнхий зүй тогтол, мөн чанар, зарчим, хандлагууд харагдаж байгаа юм.

Ялангуяа Д.Белл, О.Тоффлер, Ю.Хаяаши нар мэдээлэлжсэн нийгмийн онолын үндэс суурийг гаргаж тавьсан эрдэмтэд бөгөөд энэ талаар өөрийн судалгааны олон арван бүтээлүүдийг хэвлүүлсэн байна. Мөн мэдээллийг мөнгө шиг хадгалаж, үржүүлж түүгээр баялаг бүтээж болно гэсэн санааг О.Тоффлер гаргаж, Г.Хенс мэдээлэлжсэн нийгмийн таван тодорхойлолтыг боловсруулах үндсэн дээр техник, технологи; эдийн засаг; үйлдвэрлэл; орон зай; соёлд суурилан тайлбарлаж, 6 дахь нь онолын мэдлэг гэж үзсэн нь эдүгээ мэдээлэлжсэн нийгмийг ойлгох гол үндэс боллоо. Х.Пёркин мэдээллийн ангилал, ялгарал, логистик бүтэц, тоо, чанарын нарийн судалгаа нь уг нийгмийн онолын үндэс гэсэн нь түүний мөн чанарыг ойлгоход дөхөм болох боловуу. Практик дээр нэг жишээ авахад түүхэн ард түмнүүдийн оюуны соёлын охь болсон монгол, төвд, буддын соёлын түүхэнд бүтээгдсэн уламжлалт мэдлэг ухааныг дахин боловсруулж, мэдээлэлжсэн нийгмийн өнөөгийн нөхцөлд үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээ болгох дэлхий нийтийн хандлага, боломж болоод байна.

Үндсэн хэсэг

Нийгэм нь хүнтэй л адил өсөж, хувьсаж, өөрчлөгдөж байдаг зөрчилдөөнт хийгээд зүй тогтолт шинжтэй үзэгдэл, үйл явц мөн. Тухайн нийгмийн үйлдвэрлэлийн арга, хэлбэр, зарчим, технологи өөрчлөгдөхөд буюу аж үйлдвэржилтээс оюуны болон мэдээллийн үйлдвэрлэлийн шинэ хувьсгалт шатанд шилжих үед мэдээллийн нийгэм иргэншлийн суурь тавигдсан юм.

Онолын хувьд мэдээллийн нийгмийг байгуулах барууны болон азийн хоёр загвар байдаг. Гол ялгаа нь нэг нь өндөр хөгжсөн уураг тархины дотоод зүй тогтолд суурилсан нээлттэй загвар, нөгөө нь төрийн өндөр оролцоо, хяналт бүхий харьцангуй хаалттай загвар мөн. Харин япон нь төр, хувийн

хэвшлийн хурдатгасан загварыг хэрэгжүүлж, “Цахим Япон” хөтөлбөр боловсруулсан юм.

Мэдээлэлжсэн нийгэм байгуулах ерөнхий, тусгай, дагалдах зарчмуудыг ЮНЕСКО-гоос гаргасан баримт бичгүүд болон Женев (2003), Туннисийн (2005) тунхаглалын зарчмуудыг удирдлага болгон улс, үндэстнүүд уг нийгэмд шилжиж байгаа ч системийг хэрхэн онолын үндэстэй тохируулсанаас хамаарч гарах үр дүн нь харилцан адилгүй байгаа юм. Уг нийгэм нь урт удаан хугацаанд бүрэлдэж, одоо нэгэнт инерцээ авч, мэдээллийн хурдтай урсгал дунд ирээдүй өөрөө бүтээгдэх болов. Монголын нийгэм болон бусад хөгжиж буй улс орнуудад тулгамдаж буй гол асуудал нь мэдээлэлжсэн нийгэмд хэрхэн хөл тавих, түүнд харанхуйгаар орох уу, эсвэл мэдлэг, мэдээлэлтэйгээр орох уу? гэдэг нь тулгамдсан асуулт мөн. Иймд мэдээлэлжсэн нийгмийн суурь судалгаанд хийсэн хөрөнгө оруулалт, туршлага, сорилтууд нь биднийг чиглүүлэх луужин болно. Гэвч энэхүү глобал үнэт зүйлсийг нийгэм иргэншлийнхээ онцлог, соёл, улс төр, эдийн засгийнхаа өвөрмөц байдал, тухайн үндэстний зан төлөвт тохируулсан онолын загварыг гаргах нь судалгааны шинэ талбарыг нээж мөн.

Үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээний циклийг холбогч нь онолын мэдлэг, оюуны технологиудад төвлөрч, эдгээр нь сүлжээ, компьютер, програм хангамж, гар утсанд суурилсан хүмүүс хоорондын шинэ харилцааг үүсгэсэн нь эдийн засгийн дүр төрхийг үндсээр нь өөрчилсөн. Энэ нь үйлчилгээний технологитой нийгэмд шилжих үндэс болсноор мэдээллийн үйлдвэрлэл, үйлчилгээний эдийн засгийн гол хэрэгсэл нь мэргэжлийн мэдлэг болсон байна. Манай орны хувьд үйлчилгээний эдийн засаг ДНБ-нд 1995 онд 1.44%, 2000 онд 3.7%, 2002 онд 3.1%, 2003 онд 6.3%, 2004 онд 7.3%, 2010 онд 11% болж, тасралтгүй жилд өссөөр байна. Манай орны хувьд мэдээлэлжсэн нийгмийн тухай онолыг судалсан дорвитой бүтээл гарахгүй байгаа нь гол хомсдолын хүчин зүйл болж байна. Нийгмийн уураг тархи эрүүл, шинжлэх ухааны үндэстэй бүрэлдэхэд онолын мэдлэг, мэдээллийн гүйцэтгэх үүрэг асар их байна. Эдүгээ мэргэжлийн програм хангамж, түүн дээр ажиллах шинэ мэдээллийн мэргэжилтэн, онолын мэдлэгийн нэгдэлд ирээдүй өөрөө бүтээгдэж байна.

Монголын нийгмийн өнөөгийн бодит байдалыг хүнчлэх арга зүйгээр задлан шинжилвэл: уг нийгмийн тархи нь онолын мэдлэг, оюуны технологи; зүрх нь МХХТ; эрхтэн системүүд нь түүний дэд бүтэц болох хурдны зам; хэл яриа нь хоёрдох бичиг үсэг тайлагдалт; мэдрэмж нь харж, сонсож буй байдал; төгөлдөржилт нь МХХБАЗ-н хөгжлийн төвшин; урьчилсан нөхцөл нь итгэлцэл, мэдээлэл, сүлжээ, хэрэглэгчийн эрх; боломжийн үнэ; хувийн амьдралын халдашгүй байдал; аюлгүй байдал зэрэг мөн. Уг нийгмийн уураг тархи нь өнгөрсөн үеийн урт удаан хугацааны шинжлэх ухааны мэдлэгийн

хуримтлал. эдүгээгийн технологийн дэвшилтэй холбоотой бүрэлдсэн ба хүүхдийн уураг тархи хэрхэн өсөж томордогтой адил бүтэцжиж, бүрэлдсэн тогтоц учир үүнийг хэдэн жилийн дотор механикаар хийхэд нэн төвөгтэй.

Иймийн тулд уг нийгмийн үндсэн шинж, мөн чанарыг танин мэдсэн байх зайлшгүй шаардлага тулгарч байгаа ч зайлшгүйг танин мэдэж чадсанаар бидэнд чөлөөт байдал. боломж, өөрчлөлтийн үндсүүд тавигдах ёстой. Үүнд: Мэдээллийн үйлчилгээ, МХХТ-ийн үүрэг роль өсч оюуны үйлдвэрлэл, үйлчилгээний янз бүрийн салбарт ажиллагсдын тоо өсч, мэдээллийн либерал орон зай бий болсноор дэлхийн мэдээллийн нөөцөд хүрэх боломж нээгдэж, нийгэм жижиг бүлгүүдэд хуваагдаж, тэр нь нийгмийн гэрээний хэсэг болж, гол үнэт зүйл нь цаг хугацаа, хурд, мэдрэмж, мэдээлэл, компьютер эзэмшсэн байдал. ур чадварт суурилах болсноор МХХ-ний дэд бүтэц нь өрсөлдөх давуу талынх нь үндэс болов. МХХ-ны шинэ технологи гарч ирснээр хэн нэгэн дарга, нам. ажил олгогчдын оролцоонд үл суурилах болсноор бид өөрсдөө сонголт хийж, тэр хирээр уг нийгэм бидний хариуцлагийг нэмэгдүүлж, насан туршын суралцагсад болгожээ.

Монгол улсад МШХХ-ны салбар анх төмөр утасны хороо нэртэйгээр үүсч хөгжөөд 90 жил болж, интернэт байнга хэрэглэгчийн тоо 2001 онд 10300. 2007 онд 30000, 2010 онд 199849 болтлоо огцом өсч, 2005 оноос хэрэгжүүлсэн “Цахим монгол” үндэсний хөтөлбөрийн үр дүнд интернэтийн хэрэглээ 18.8 дахин нэмэгдсэн ба цаашид 20-25% нэмэгдэнэ гэдгийг судлаачид баталж байна⁸³.

ХАОСТ-2010 эмхтэглийн хүрээнд 12 сэдэвчилсэн судалгаа гаргаснаас интернет, гар утас хэрэглэгч судалгааны дүнгээс үзвэл монголын нийгэмд уг *нийгмийн гар, хөл нэгэнт бүрэлдсэн дүр зураг харагдаж байна*. Эндээс үзэхэд гар утастай харьцуулахад интернэт хэрэглэгчид боловсролын төвшинтэй хүчтэй хамааралтай байдаг нь зүй тогтол бөгөөд доктор, магиструудын 90.4%, дипломын болон бакалаврын боловсролтой хүмүүс 70.1% , бүрэн дунд боловсролтой хүн 34.5% байгаа нь техник мэргэжлийн боловсролтой хүн амын хэрэглээнээс дээгүүр ба боловсролгүй хүмүүсийн 7.6% нь интернет хэрэглэж, бичиг үсэг мэддэггүй хирнээ интернет хэрэглэдэг 857 хүн байгаа нь сонирхол татаж, энэ нь нийгмээрээ мэдээлэлжих хандлагад шилжиж буйн дохио мөн. Хүүхэд залуучуудын 63.5% нь гэртээ интернэттэй болсон нь өсвөр үеийнхэнд зориулсан мэдээлэлжсэн, мэдлэгийн нийгмийн бодлогыг явуулах шаардлагыг бий болгож байна⁸⁴.

⁸³ Мэдээлэл, шуудан, харилцаа холбооны салбарын 90 жилийн ойн материал. МШХХТГ-ийн дарга Ж. Бат-Эрдэнэ УБ „2011 он, 3 дахь талд

⁸⁴ ХАОСТ-2010 : Гар утас, интернэт хэрэглэгч 27-55 дахь талд

Мөн шилэн кабелийн сүлжээ 21 аймгийн 160 суманд хүрч, давхардсан тоогоор 2.5 сая иргэн үүрэн телефон хэрэглэж⁸⁵ байгаа нь үүрэн холбооны нийгэм, мэдээллийн нийгэм байгуулах суурь бүтэц нэгэнт бүрдсэнийг харуулж байна. Эндээс бид нийгмийн компьютержүүлэлт, мэдээлэлжүүлэлтийн ялгааг гаргах хэрэгтэй. Компьютержүүлэлт нь компьютерийн техникийн баазыг бэхжүүлэхэд илүү анхаардаг бол мэдээлэлжүүлэлт нь хүний үйл ажиллагааны бүх чиглэл дэх үнэн магад, бүрэн төгс мэдлэгийг цаг үед нь бүрэн дүүрэн ашиглахад чиглэсэн цогц арга хэмжээ мөн. Монгол Улс мэдлэгт суурилсан мэдээлэлжсэн нийгмийг байгуулах хоёр шаттай хөтөлбөрт 2004-2010 онд мэдээлэлжсэн нийгмийн суурийг бүрдүүлнэ 2010-2020 онд уг нийгмийг бүрэн утгаар нь байгуулж, технологийн ололтыг нийгэм эдийн засгийн бүх салбар, хүн бүрийн өдөр тутмын хэрэгцээ, шаардлага болгоно гэж томъёолсон.

Мөн 2009 оны 07 сарын 09 ны өдрийн 123 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж, ҮХШХ-оос санал оруулснаар өндөр технологийн аж үйлдвэрлэлийн талаар төрөөс баримтлах бодлого, МУИХ-ын 1998 оны 05 сарын 14 өдрийн 55 дугаар тогтоолоор шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого гэх мэт бодлогын шинжтэй 450 гаруй баримт бичгүүд боловсруулагдаж байгаа ч хэрэгжилт хангалтгүй байгаа нь шинжлэх ухааны онолын мэдлэгт суурилсан мэдээллийн нийгмийн тархи бүрэлдэхэд саад тотгор болж, агуулга хэлбэрийн зөрчил үүсэх суурь болов.

Орос орон мэдээлэлжсэн нийгмийн хөгжлийн стратегиа боловсруулж, уг нийгмийн байгуулал нь шинэ формац, хүн төрөлхтний глобал шинжтэй соёл иргэншлийн ирээдүй, шинэ үзэл баримтлал, нийгмийн өөрчлөлтийн хамгийн боловсронгуй хэлбэр болохыг хүлээн зөвшөөрөх боллоо. ОХУ-д мэдлээлэлжсэн нийгэм хэрхэн байгуулж буй талаар миний бие өөрийн диссертаци (2013), нэг сэдэвт бүтээл (2014) болон ХХI зуунд мэдээлэлжсэн нийгэм байгуулах Женев болон Туниссийн тунхаглалын зарчим (2014) бүтээлүүддээ тодорхойлон гаргасан байгаа. Гэтэл манай орны хувьд мэдээлэлжсэн нийгэм байгуулах үндсэн стратегийн онол, арга зүйн үндэслэл харахан боловсруулагдаагүй байгаа нь нийгмийн өөрчлөлтийн асар их боломжийг алдаж буй хэрэг мөн. Иймд манай орон мэдээлэлжсэн нийгэм байгуулах үндсэн стратегиа тодорхойлох нь шинэ монголын хувьд тулгамдсан асуудал бүхий судалгааны шинэхэн талбарыг нээж байна.

Эндээс үзэхэд мэдээллийн үйлчилгээнд шилжсэнээр ажил эрхлэлт нэмэгдэн, МХХТ-ийн хэрэглээ өсч, гол үйлдвэрлэл нь мэдээллийн болон соёлын аж үйлдвэрлэл, үйлчилгээ болсноор олон боломж, давуу тал бий болж

⁸⁵ Мэдээлэл, шуудан, харилцаа холбооны салбарын 90 жилийн ойн материал. МШХХТГ-ийн дарга Ж. Бат-Эрдэнэ УБ „2011 он, 5 дахь талд

байгаа ч түүнээс дутахгүй сөрөг үр дагавар. аюул занал гарч байгаа юм. Иймд аливаа зүйл эерэг, сөрөг талтайн учир уг нийгмийн боломж, давуу талыг дээд зэргээр ашиглан. аюул занал, сул талыг хамгийн доод түвшинд барих арга зүй нь бидний гол зарчим байх ёстой. Кибер гэмт хэрэг, хакер, какеруудаас сэргийлэх бүтэц манай цагдаагийн байгууллагад бий болж байгаа нь нэг том дэвшил мөн. Онлайн орчинд ажиллаж, амьдрах нь хувь хүнээс МХБАЗ-н шинэ мэдлэг. өндөр анхаарал, сэрэмж, мэдрэмж, соёл, онлайн ёс суртахууныг шаарддаг гэдгийг анхаарах хэрэгтэй. Учир нь уг нийгмийн аюул занал, сөрөг талууд нь аль хэдийн орж ирээд байраа эзэлчихсэн байдагт байгаа юм. Нөгөө талаас постсоциалист орнууд шинэ глобал үнэт зүйлсийг өөрийн соёлын хэв маягт тохируулан сонгодог утгыг нь алдагдуулдаг сул тал бий.

Дүгнэлт

Монголын нийгэмд мэдээлэлжсэн нийгмийн гар хөл нь бүрэлдэж, зүрх нь цохилж эхэлж байгаа бөгөөд инкубатор оруулан амилуулахад нэлээдгүй хүч. чармайлт, бодлого, санхүүжилт шаардагдана. Хэрэв тархи эрүүл саруулаар ажиллаж эхэлбэл монголын нийгмийн ирээдүйд урьд хожид байгаагүй асар их боломж, эерэг өөрчлөлтийг авчирах нь гарцаагүй. Иймд уг нийгэмд зүгээр урсгалаараа орчихож болохгүй бөгөөд түүнийг шинжлэх ухааны үндэстэй танин мэдэж, түүний ирээдүйд чиглэсэн бодлогыг боловсруулах шаардлага манай нийгмийн өмнө тулгарч байна. *К.Поппер нийгмийг асуудалаа шийдвэрлэх зохион байгуулалт, түүнийгээ хэрхэн шийдвэрлэж буй чадвараар нь үнэлэх ёстой* гэжээ. Иймд мэдээлэлжсэн нийгэмд сүлжээний зохион байгуулалт, МХБАЗ-н тусламжтайгаар олон чухал асуудлуудыг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран виртуаль (жинхэнэ бус бодит байдал) хүрээнд шийдвэрлэх боломжууд нээгдсэн юм. Мэдээлэлжсэн нийгмийн зохион байгуулалт нь нийгмийн хөгжлийг автоматаар 25%-аар өсгөдөг болох нь оросын эрдэмтэн Ю.В.Юзвигиний судалгаагаар батлагдаж байгаа юм. Нийгмийн организмын цусан хангамж нь мэдээлэл, мэдлэгийг хэрхэн үр ашигтай, хурдтайгаар дамжуулан боловсруулж, орчин үеийн шинэ технологиудыг нэвтрүүлж буйгаар тодорхойлогдох боллоо. Энэ нь хүмүүний нийгмийн хөгжил дэх хувслын шинэ үйл явцын эхлэл болж байгаа бөгөөд үүнийг мэдээлэлжүүлэлт гэж нэрлэж байна. Мэдээлэлжсэн үндэстнүүд болох АНУ, Солонгос, Энэтхэгтэй харьцуулахад гар утас, интернэт хэрэглэгчийн хувь бараг ижил, зарим үзүүлэлтээр илүү байгаа ч манай орны хувьд ДНБ-нд үйлчилгээний эдийн засгийн эзлэх хувь, чанарын төвшин хэт бага байна. Мэдээллийн аж үйлдвэрлэл, үйлчилгээний эдийн засагт аж үйлдвэржсэний дараах нийгмээс АНУ, Канад \75, 74,\ хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа нь тоон гэхээсээ чанарлаг шинжийг агуулж, хэр зэрэг мэдээлэлжсэн үндэстэн вэ? гэдгийн илэрхийлэл мөн. Нөгөө талаас уг салбарт хийх хөрөнгө оруулалт

хамгаас чухал бөгөөд АНУ дэлхийн шинжлэх ухааны боловсруулалтын 45%-ийг дангаараа хийж, патент эзэмшигчид 95%-д хүрээд байна. 2010 онд монголд хийсэн гадаадын хөрөнгө оруулалтын 89% нь уул уурхай, 10% нь МТ-ийн салбарт оногдож байгаа нь уг нийгмийн тархи бүрдэх боломжийг хязгаарлах хомсдлын хүчин зүйл мөн. Мэдээлэлжсэн хүн, байгууллага, нийгэм, улс үндэстэн бол гурав дахь мянганы оюуны технологийн хөгжлийн эрчимжилтийн эрин үеийн гол үнэт зүйлс боллоо. Монгол орон аж үйлдвэржсэний дараах хөгжлийн эл загварыг бүтээлчээр хэрэгжүүлэх нь улс орны эдийн засгийг олон тулгуурт бүтэц бий болох, улс орны аюулгүй байдал технологийн төвшинд хангагдах, инновацийн бүтээгдэхүүн-үйлчилгээгээр дэлхийн мэдлэг, мэдээллийн зах зээлд өрсөлдөх өргөн боломжийг өөртөө тээж байгаа билээ.

Зөвлөмж

1. Шинжлэх ухааны тэргүүлэх салбарыг оновчтой тодорхойлж, салбарын судалгааны үр дүнг сайжруулах
2. Шинжлэх ухаан боловсролын салбарт амжилт гаргасан иргэдэд олгох урамшууллыг эрс нэмэгдүүлэх
3. Сонгодог дээд боловсролыг хадаглаж, хөгжүүлэхдээ МХТ-ийн боловсруулах арга зүйн ололтыг өргөнөөр ашиглах
4. Соёл, боловсрол, аялал жуулчлал, эрүүл мэнд, банк санхүү, удирдлага зэрэг төрийн үйлчилгээний салбарт МХТБАЗ-н ололтыг ашиглах
5. Дотоодын мэдээллийн технологийг хөгжүүлэхэд олон улсын санхүүгийн байгууллагын нөөц, боломжийг ашиглах
6. Мэдээллийн эх сурвалжид чөлөөтэй нэвтрэх эрх зүйн орчныг бүрдүүлэх
7. МХТ-ийг ашиглах хүрээнд гэмт хэрэг үргэлж буурч байх, кибер гэмт хэргийн өсөлтийг бага дээр нь таслан зогсоох технологийг импортлох, боловсруулахад гадаад, дотоодын үнэ цэнэтэй мэргэжилтэн, судлаач эрдэмтдийг урьж оролцуулах
8. Олон улсын мэдээллийн эсрэг гэмт хэрэг, улс төр, алан хядах болон бусад гэмт хэргийг илрүүлэх технологийг боловсруулахад хууль сахиулах байгууллагуудыг оролцуулах
9. Иргэдийн мэдээлэлжсэн нийгэмд эзлэх байр суурь, эрх чөлөөг улсаас баталгаажуулж, тэдэнд тэгш боломжийг олгох
10. 1000 хүнд оногдох интернэт үйлчилгээний тоо, чанарт ахиц дэвшил гаргах
11. 1000 хүнд оногдох доткорын тоо, чанарт ахиц дэвшил гаргах
12. МХТ болон МХБАЗ-н хэрэглээг эрс нэмэгдүүлж дараах салбарыг тодорхой хувьд хүргэх зорилт тавих. Үүнийг ОХУ тай харьцуулж үзвэл

монгол улс илүү ахисан төвшинд мэдээлэлжсэн нийгмийн үндсэн хэрэглээг бий болгох боломж харагдаж байна Үүнд:

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС			МОНГОЛ УЛС	
1.	Эмч	40%	Эмч	65%
2.	Дунд сургуульд	50%	Дунд сургуульд	70%
3.	Дээд сургуульд	70%	Дээд сургуульд	80%
4.	Мэргэжлийн багшийн эзлэх хувь	60%	Мэргэжлийн багшийн эзлэх хувь	85%
5.	Электрон каталоги	39%	Электрон каталоги	90%
6.	Музейн сангийн электрон каталоги	50%	Музейн сангийн электрон каталоги	88%
7.	Архивын сангийн электрон каталоги	15%	Архивын сангийн электрон каталоги	75%

Ингэснээр монгол орон аж үйлдвэржсэний дараах үсргэнгүй хөгжлийн замд орох бөгөөд хөгжингүй бүх улс орнууд мэдээлэлжсэн нийгэм иргэншлийн замыг сонгон хөгжиж байна. Гэтэл зарим постсоциалист орнууд аж үйлдвэржилтийн хойноос улайран хөөцөлдөж байгаа юм. Үүнд л уг судалгааны онол-танин мэдэхүй, арга зүйн ач холбогдол оршиж байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. Ц.Батбаяр. Аж үйлдвэржсэний дараах нийгмийн тухай үзэл баримтлалд хийсэн философи шинжилгээ. УБ., 2013. (дисс)
2. Ц.Батбаяр. Аж үйлдвэржсэний дараах нийгэм үйлчилгээний технологитой нийгэм болох нь: Нийтийн үйлчилгээ УБ., 2014.
3. Ц.Батбаяр. XXI зуун дахь мэдээлэлжсэн нийгэм байгуулах Женев болон Туниссийн тунхаглалын зарчим. УБ., 2014.
4. Мэдээллийн технологийн хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын зорилт. УБ., 2005 хамтын бүтээл: Ажлын хэсгийн ахлагч Р.Ганболд, гишүүд А.Эрдэнэбаатар, Б.Бадамсүрэн нар
5. Мэдээлэл, шуудан, харилцаа холбооны салбарын 90 жилийн ойн материал. МШХХТГ-ийн дарга Ж.Бат-Эрдэнэ УБ., 2011 он
6. ХОАСТ-2010 : Сэдэвчилсэн судалгаа “Гар утас, интернэт хэрэглэгч” УБ., 2011 он
7. Батбаяр.Ц. Информационное общество и его реальное состояние в современной Монголии”, “Философия, социология, политология, культурология. № 14, Улан-Үде., 2012
8. Иноземцев.В.Л. Вестернизация как глобализация и “глобализация” как американизация. Вопросы Философии. № 4. М., 2004

9. Кузьмин.Е.И, Фирсов.В.Р. Формирование информационного общества в XXI веке. СПб., 2006
10. Кеван.К. Революция услуг в мировой экономике. М., 2007
11. Панарин.И.Н. Технология информационной войны. М., 2007
12. Тузовский.И.Д. Светлое завтра? Антиутопия футурологии и футурология антиутопии. Челябинск., 2009
13. Юзвешин.И.И. Основы информациологии. М., 2001
14. Яковец.Ю.В. Формирование постиндустриальной парадигмы: истоки и перспективы. Вопросы Философии. №1. М., 1997
15. Якунин.В.И. и др., Постиндустриализм: опыт критического анализа. М., 2012
16. D.Bell. Грядущее постиндустриальное общество. М., 1998;
17. D.Bell. Marxian Socialism in the United States. Ithaca - L., 1995;
18. D.Bell. The Social Sciences since the Second World War. New Brunswick-L., 1982;
19. D.Bell. The End of Ideology. Cambr. (Mass.) - L., 1986;
20. D.Bell. The Coming of Post-Industrial Society. N.Y., 1973; 1999
21. D.Bell. The Cultural Contradictions of Capitalism. N.Y., 1976;
22. D.Bell. The Social Framework of the Information Society. Oxf., 1980;
23. D.Bell. Sociological Journeys. Essays 1960-80. L., 1980;
24. D.Bell. The World and the United States in 2013. N.Y., 1987;
25. Bell D., Graubard S. R. Toward the Year 2000. Work in Progress. Cambr. (Mass)- L., 1986;
26. D.Bell. *Kristol L.* (eds.). The Crisis in Economic Theory N.Y., 1981.
27. F. Webster. Theories of the information society. Third edition USA 2008